

### Клиникийн 3 дугаар Амаржих газар

Амаржих газар нь 1966 онд Улаанбаатар хотын Найрамдлын районд Улаанбаатар хотын Эрүүлийг Хамгаалах Газрын харьяа 3 төрөх нэртэйгээр байгуулагдсан.

МУ-ын ЭМ Нийгмийн Хамгааллын Сайд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн А/56, А/34 тоот хамтарсан тушаал НЭМГ-ын даргын 20 тоот тушаалаар 1998.02.28-ний өдөр татан буугдсан.

Нийслэлийн Амаржих газруудын ачаалал, нягтрал нэмэгдэж, эх нярайн халдвар буурахгүй байгааг харгалзан Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 114 дүгээр тогтоолоор дахин байгуулагдах шийд гарч 1999 оны 11 дүгээр сарын 16-ний өдрийн Эрүүл мэндийн Нийгмийн хамгааллын Сайд, Нийслэлийн Засаг даргын А/282, А/233, тоот тушаал, захирамжаар Зэвсэгт хүчний клиникийн төв амбулатори байрлаж байсан барилгыг чөлөөлж засвар үйлчилгээ хийж, Нийслэлийн 3 амаржих газрыг төрхийн 60 ортой 84 эмч, ажиллагсад-тайгаар 2000 оны 8 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн нээн ажиллуулсан.

Тус амаржих газрыг 1999 онд дахин байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлэхэд анхны ерөнхий эмчээр Төмөртэйг овогтой Дорж-пүрэв /1999.11.01.-2001.01.03/ томилогдон ажилласан.

Улмаар их эмч Ё.Тэрбиш /2001.01.03-2005.02.14/ онд, 2005 оноос одоог хүртэл Д.Бат-Очир ерөнхий эмчээр ажиллаж байна.

Тус амаржих газар нь 45 ортой, захиргаа санхүү аж ахуйн, эмнэлгийн тусламж үйлчилгээ гэсэн 5 үндсэн тасаг, нэгжтэйгээр удирдах ажилтан 5, их эмч 21, сувилагч 16, эх баригч бага эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн 21 захиргаа аж ахуйн 33 ажилтан, нийт 96 хүний бүрэлдэхүүнтэй жилдээ 5000 гаруй эх, эмэгтэйчүүдэд үйлчилж, эх барихын болон яаралтай тусламж үйлчилгээ үзүүлдэг.

Үндсэн үйл ажиллагаа нь эхийг эсэн мэнд амаржуулах, эрсдэл өндөртэй жирэмсэн эхэд стандартын дагуу нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх, эх нярайн яаралтай тусламж үйлчилгээ, сувилахуйн тусламж үйлчилгээ, НҮЭМ-ийн хөтөлбөр хэрэгжүүлэх, эх эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн /нөхөн үржихүйн/ боловсрол олгодог.

Мянганы хөгжлийн зорилт, 2006-2010 хүртэл эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэхээр боловсруулсан мастер төлөвлөгөө, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний гурав, дахь хөтөлбөрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Эмчилгээний тасгууд нь үйлчлэх хүрээнийхээ хүн амд эх барихын тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр төвшинд үзүүлж, жилд дунджаар 5000 гаруй хүнийг хэвтүүлэн эмчилж, 3500 гаруй эхийг эсэн мэнд амаржуулж байна.

Захиргаа аж ахуйн тасаг нь Захиргааны ба эдийн засгийн төлөвлөлт, санхүү, нягтлан бодогч бүртгэл, эм ороох боох материал, аж ахуйн хангамж үйлчилгээ, харуул хамгаалалт зэрэг арын албыг найдвартай хариуцан, эмнэлэг үйлчилгээний хэвийн жигд үйл ажил гааг хангаж ажилладаг. Эх нярайн үзүүлэх тусламжийн оношлог-оо эмчилгээний стандартыг эмчилгээ үйлчилгээнд мөрдөхөд чанарын албаны зүгээс хяналт тавьж

эмнэлгийн дотоод халдвар хамгаалал, эмчилгээ үйлчилгээг хэвийн явуулах ажлыг болон дотоод сургалтыг хариуцан ажилладаг.

Үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг тасаг бүрийн онцлог болон үйлчлүүлэгчдийн ачааллаас хамааруулан 14 хоног тутамд авч дүн шинжилгээ хийж, түүний дагуу сар бүр ажлаа төлөвлөн ажиллаж байна.